



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/7506

Улаанбаатар хот

2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн
төлөвлөгөөг дүгнэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 206, 2023 оны 301 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээг хавсралтаар баталсугай.

2.“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нарт үүрэг болгосугай.

3.Жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр “Маш сайн”, “Хэвийн” үнэлэгдсэн байгууллагуудын удирдлагад холбогдох журамд заасан урамшууллыг цалингийн санд багтааж олгохыг байгууллагын нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

4.Байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон цаг үеийн шинжтэй хугацаатай өгсөн үүрэг даалгаврын үр дүнг тооцож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110206907

Нийслэлийн Засаг даргын 20

12 дугаар сарын 23

А/1506 дугаар захирамжийн

хавсралт



НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Нэг. Дүүргийн Засаг дарга нарын хариуцлагын гэрээний гүйцэтгэлийн үнэлгээ:

Маш сайн: (Үсгийн дарааллаар)

1. Сонгинохайрхан дүүрэг

Хэвийн: /Үсгийн дарааллаар/

1. Багануур дүүрэг
2. Багахангай дүүрэг
3. Баянгол дүүрэг
4. Баянзүрх дүүрэг
5. Налайх дүүрэг
6. Сүхбаатар дүүрэг
7. Хан-Уул дүүрэг
8. Чингэлтэй дүүрэг

Хоёр. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын гүйцэтгэлийн
төлөвлөгөөний үнэлгээ:

Маш сайн: /Үсгийн дарааллаар/

1. Архивын газар
2. Газар зохион байгуулалтын алба
3. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
4. Нийслэлийн Цагдаагийн удирдах газар
5. Онцгой байдлын газар
6. Өмчийн харилцааны газар
7. Татварын газар

Хэвийн: /Үсгийн дарааллаар/

1. Байгаль орчны газар
2. Биеийн тамир, спортын газар
3. Бизнес, инновацын газар
4. Боловсролын газар
5. Дотоод аудитын алба
6. Замын хөгжлийн газар
7. Мал эмнэлгийн газар
8. Нийслэлийн Аялал жуулчлалын газар
9. Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар
10. Нийслэлийн Статистикийн газар
11. Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар



12. Нийтийн тээврийн бодлогын газар
13. Орон сууцны бодлогын газар
14. Соёл урлагийн газар
15. Улсын бүртгэлийн газар
16. Хот байгуулалт, хотын стандартын газар
17. Хүнс хөдөө аж ахуйн газар
18. Хяналт шалгалтын газар
19. Эрүүл мэндийн газар

Хангалтгүй: /Үсгийн дарааллаар/

1. Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар

Гурав.Орон нутгийн өмчит төсөвт байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ:

Маш сайн: (Үсгийн дарааллаар)

1. Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ
2. Монголын Хүүхдийн ордон ОНӨТҮГ
3. Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төв ОНӨТҮГ
4. Улаанбаатар хотын Нийтийн номын сан ОНӨТҮГ

Хэвийн:/Үсгийн дарааллаар/

1. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ
2. Монголын Хүүхдийн урлан бүтээх төв ОНӨТҮГ
3. Нийгмийн хамгааллын тусгай төв ОНӨТҮГ
4. Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв НӨҮГ
5. Нийслэлийн төр захиргааны авто бааз
6. Улаанбаатар лифт ОНӨТҮГ
7. Улаанбаатар театр ОНӨТҮГ
8. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж
9. Улаанбаатар хотын музей ОНӨТҮГ
10. Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ
11. Хүүхэд залуучуудын сургалт, хүмүүжлийн тусгай төв ОНӨТҮГ

Дөрөв.Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ:

Маш сайн: (Үсгийн дарааллаар)

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар